



**НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2013 оны 11 сарын 25 өдөр

Дугаар 79

Улаанбаатар хот

Сургалт, семинар зохион
байгуулах тухай

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3, 3.2.6 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Нийслэлийн нутаг дэвсгэрт байршилтай музейн менежер, тайлбарлагч нарт зориулсан “Музей, үзвэрийн газруудын жуулчны менежмент” сэдэвт сургалт, семинар зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, зарцуулах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Сургалтын төсөв болох 67,000 /жаран долоон мянган/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.


Гурав. Сургалтыг удирдамжид заасан хугацаанд зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Мэргэжлийн сургалт хариуцсан мэргэжилтэн /Ш.Ундармаа/-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Э.БАТТУЛГА

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2013 оны 11 сарын 25 ны өдрийн
79 тоот тушаалын нэгдүгээр хавсралт



**“МУЗЕЙ, ҮЗВЭРИЙН ГАЗРУУДЫН ЖУУЛЧНЫ МЕНЕЖМЕНТ”
СЭДЭВТ СУРГАЛТ, СЕМИНАРЫН УДИРДАМЖ**

Зорилго: Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг музей, үзвэрийн газрын ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, харилцан туршлага солилцох боломжийг олгох, гадаад орнуудын туршлагыг танилцуулах, жуулчидтай харилцах менежментийг сайжруулахад энэхүү сургалтын зорилго оршино.

Сургалтын хөтөлбөр:

Д/д	Сэдэв	Заах багш	Хугацаа
1	Нээлт	Э.Баттулга /Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дарга/	9:00 – 9:05
2	Улаанбаатар хотын музей, үзвэрийн газруудын өнөөгийн байдал ба жуулчдын сэтгэгдэл, хэрэгцээ, хандлага	Ч.Буянбадрах /Олон улсын аялал жуулчлалын хөгжлийн төв/ урилгаар	9:05 – 10:00
3	Хотын аялал жуулчлалд музейн гүйцэтгэх үүрэг	Ч.Буянбадрах /Олон улсын аялал жуулчлалын хөгжлийн төв/	10:00 – 11:30
4	Завсарлага /Цайны цаг/		11:30 – 12:00
5	Жуулчинд ээлтэй музейн орчинг бий болгох менежмент	Ч.Буянбадрах /Олон улсын аялал жуулчлалын хөгжлийн төв/	12:00 – 12:45
6	Музейн соёлын өвөөрөө бусад орноос юугаараа ялгаатай вэ?	Г. Бадамсамбуу /Гараг студийн захирал/ урилгаар	12:45 – 13:45
7	Музей ба маркетинг	Б.Оюунзул /Нийслэлийн Аялал жуулчлалын газрын мэргэжилтэн/	13:45 – 14:45
	Гэрчилгээ олгох		14:45 – 15:00

Хамрах хүрээ: Нийслэл хотод үйл ажиллагаа явуулж буй музей, үзвэрийн газруудын менежер, тайлбарлагчид хамрагдана.

Зохион байгуулагч: Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Олон улсын аялал жуулчлалын хөгжлийн төв

Хугацаа: 2013 оны 12-р сарын 05-ны өдөр зохион байгуулагдана.


Хүрэх үр дүн: Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй музейн ажилтнуудын мэргэжлийн ур чадвар дээшилж, жуулчдад үзүүлэх үйлчилгээ сайжирна.

Хаана болох:

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дэргэдэх Аялал жуулчлалын мэдээлэл, сурталчилгааны төв /Бага тойруу-15 Чингэлтэйдүүрэг, 4-р хороо, Нийслэлийн Засаг захиргааны 4-р байр хуучнаар Улаанбаатар банкны байрны Баруун хойд талын хаалга/

Холбоо барих утас: 7012-8687, 99838674

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2013 оны 11 сарын 25-ны өдрийн
49 тоот тушаалын хоёрдугаар хавсралт



“МУЗЕЙ, ҮЗВЭРИЙН ГАЗРУУДЫН ЖУУЛЧНЫ МЕНЕЖМЕНТ”
СЭДЭВТ СУРГАЛТ, СЕМИНАРЫНТӨСӨВ

№	Зардлын зүйл	Тоо	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Бүгд үнэ /төгрөг/
1.	Гэрчилгээ хэвлүүлэх	60	700	42000
2.	Цай, кофе			25000
3.	Нийт дүн			67000

Хянасан: Ахлах нягтлан бодогч

П.Ариунаа

Боловсруулсан:

Ш.Ундармаа